



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ  
АСУУЛТ

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг  
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон  
Утас: 26-70-16, Факс: 32-70-16  
E-mail: stategreatkhural@parliament.mn  
http://www.parliament.mn

2024.11.25 № 41

БОЛОВСРОЛЫН САЙД  
П.НАРАНБАЯР ТАНАА

Монгол Улсын Засгийн газрын  
2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн  
25 тогтоолын хэрэгжилтийн талаар

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр “Журам батлах тухай” 25 дугаар тогтоолыг гаргаж, түүний хавсралтаар Боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагааны болон багшийн ажлын гүйцэтгэл, чанар, үнэлгээний үр дүнд үндэслэн олгох нэмэлт урамшууллыг санхүүжүүлэх журмыг батлан гаргаж, хэрэгжүүлж эхлээд байна. Иймд

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13 дахь заалт, 37 дугаар зүйлийн 37.1.1 дэх заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Танд дараах асуултыг тавьж байна. Үүнд:

1. 2022-2023 болон 2023-2024 оны хичээлийн жилүүдэд Багшийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээнд нийт хэдэн багш оролцож, түүнээс хэдэн багш нь хэддүгээр түвшинд үнэлэгдэж, нийт хэдэн төгрөгийн урамшуулал олгосон талаарх мэдээллийг сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсролын түвшин тус бүрээр;
2. 2022-2023 болон 2023-2024 хичээлийн жилүүдэд Боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагааны гүйцэтгэлийн үнэлгээнд хэдэн сургалтын байгууллага оролцож, түүнээс хэдэн сургалтын байгууллага нь хэддүгээр түвшинд үнэлэгдэж, нийт хэдэн төгрөгийн урамшуулал олгосон талаарх мэдээллийг сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсролын түвшин тус бүрээр;
3. 2023-2024 оны хичээлийн жилийн Боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагааны гүйцэтгэлийн үнэлгээний мэдээллийг 2024 оны 9 дүгээр сард аймаг, нийслэлийн боловсролын газраар дамжуулан мэдээлсэн дүн Боловсролын ерөнхий газрын даргын 2024 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн “Сургалтын байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнгийн нэмэлт урамшууллын санхүүжилт олгох тухай” А/355 дугаар тушаалын хавсралтаар баталгаажсан жагсаалтаас зөрөх болсон шалтгааны талаарх мэдээллийг тус тус ирүүлнэ үү.

2024000086

Асуултын хариуг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2-т заасан хугацаанд бичгээр ирүүлэхийг хүсье.

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН



Ц.МӨНХТУЯА

2024000066